

Үсчний мэргэжлийн үг хэллэгийн үгийн сангийн онцлог  
(бүрэлдэхүүн, гарал, бүтцийн судалгаа)

Гөрөөчингийн ГЭРЭЛМАА\*

Монгол Улс, Улаанбаатар хот, Шинжлэх Ухааны Академи,  
Хэл зохиолын хүрээлэн, Харьцуулсан хэл шинжлэлийн салбар

Received: August 15, 2025 | Accepted: November 26, 2025 | Published: December 30, 2025

*Хураангуй:* Энэ өгүүлэлд хүн төрөлхтний эртний мэргэжлийн нэг болох үсчний ажил мэргэжил үгийн сан ямар бүрэлдэхүүнтэй илэрдэг, ямар хэлнээс гаралтай үг олон байгаа, энэ мэргэжлийн үг хэрхэн бүтдэг талаар хэлний жишээ баримтад тулгуурлан тайлбарласан болно. Судалгааны хэрэглэгдэхүүнээ үсчин мэргэжилтэй 3 хүнтэй уулзаж цуглуулснаас гадна үсний тухай зөвлөгөө, гарын авлага болон вэб сайтаас цуглуулсан тул үсчний мэргэжилд түгээмэл хэрэглэдэг 222 үгийг жагсаан ангилж дараах өгүүллийг бичлээ. Нэгдүгээр хэсэгт үсчний ажил мэргэжлийн үгийн сангийн бүрэлдэхүүнийг тодорхойлж үзвэл, нэр томъёо 38%, үйл үг 33%, багаж хэрэгслийн нэр 19%, бүтээгдэхүүний нэр 10%-ийг тус тус эзэлж байв.

Хоёрдугаарт хэсэгт үсчний мэргэжлийн үгийн гарлын үүднээс судалж, уугуул болон ормол үг хэмээн ангилан үзэхэд, уугуул үг 67.1 %, ормол үг 32.9%-ийг эзэлж байна.

*Түлхүүр үг:* үсчний мэргэжлийн үг хэллэг, үг хэллэгийн бүтэц, гарал, мэргэжлийн үгийн бүрэлдэхүүн, уугуул болон харь үг

\* © Г.Гэрэлмаа, 2025

Email: [gerelmaag@mas.ac.mn](mailto:gerelmaag@mas.ac.mn),  <https://orcid.org/0000-0001-5316-0233>



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license.

## Lexical Characteristics of Hairdressing Professional Vocabulary (A Study of Structure, Origin, and Structure)

GERELMAA Guruuchin

Department of Comparative Linguistics, Institute of Language and Literature,  
Mongolian Academy of Sciences, Ulaanbaatar, Mongolia

---

**Abstract:** This article examines the vocabulary of the hairdressing profession—one of the oldest occupations in human history—focusing on its linguistic formation and the source languages of many commonly used terms, supported by illustrative linguistic examples. The research data were gathered from interviews with three professional hairdressers, as well as from hairdressing advice materials, manuals, and relevant websites. A total of 222 frequently used hairdressing-related words were identified, compiled, and systematically classified. In the first section, the internal composition of the hairdressing professional vocabulary is analyzed: terms constitute 38% of the corpus, verbs account for 33%, names of tools represent 19%, and product names make up 10%. The second section explores the vocabulary from an etymological perspective, categorizing the items into native and borrowed words. The findings show that native words comprise 67.1% of the vocabulary, while borrowed words account for 32.9%.

**Keywords:** hairdressing terms, structure of professional vocabulary, etymology, native and borrowed words

---

### 1. Удиртгал

Хүн төрөлхтөн олон төрлийн ажил мэргэжлийг эзэмшсэн бөгөөд тэдгээр нь хэлний өөрийн өөрийн онцлогтой байдаг агаад үүнийг хэл шинжлэлд хэрхэн тодорхойлж байгааг авч үзвэл, үгийн сангийн бүрэлдэхүүнд ажил мэргэжилтэй холбоотой үг хэллэг багтах бөгөөд олон хэлний үгийн санд байдаг түгээмэл үзэгдэл тул мэргэжлийн үг хэллэг (анг.professionalism) хэмээн томъёолдог.

Үүнийг эрдэмтэд тодорхойлохдоо, “Нэр томъёотой туйлын ойролцоо зүйлийн нэг нь мэргэжлийн үг хэллэг (профессионализм) болно. Мэргэжлийн үг нь аль нэгэн хөдөлмөрийн хуваарьтай холбогдон хэрэглэгдсээр ирсэн. Жишээ нь: анчин, сийлбэрчин, будагчин, төмөрчин, модчин, оёдолчин гэхэд эд нарын тус тусын ажил төрлийн өвөрмөц онцлогоос болж өөр өөрийн тусгай мэргэжлийн үг хэллэгтэй байх нь тодорхой хэрэг. Мэргэжлийн үгийг өөр төрлийн мэргэжлийн хүн ихэвчлэн мэддэг бөгөөд нэр томъёог бодвол энгийн хялбар байдалд урсгалаараа зохиогдсон байдаг байна” (Төмөрцэрэн, 1974:103) хэмээн өгүүлсэн байна.

Орчин үед мэргэжлийн үгийг “Тухайн мэргэжлийн бүлгийн ярианы онцлог шинжийг тусгасан үг болон хэллэгээс бүтэх бөгөөд ихэвчлэн тохирох утгатай нэр томъёоны дүйцэл шинжтэй үгс байдаг. Жишээлбэл, уурхайчдын ярианд “уулын өөд” гэдэг нь “уурхайд ажиллах” гэсэн утга илтгэдэг бол жолооч нарын ярианд “жолооны хүрд” гэдгээр “жолоо барих” хэмээх утгыг илэрхийлж болно (НСИС, 2006:523) гэх буюу “тодорхой мэргэжлийн бүлгийн ярианы шинж чанартай үг болон хэллэг нь мэргэжлийн үг юм. Тухайлбал, газрын гадаргууд өгөх (уурхайчдын ярианд: уурхайгаас газрын гадаргуу хүртэл явуулах). Шоргоолжны үүр, овъёос, тас шувуу (анчдын ярианд, хүрэн баавгайн төрлийн нэр). Лонх (далайчдын ярианд, хагас цаг). Зузаан хөлтэй, хазаартай (нохой үржүүлэгчдийн ярианд: нохойны чанар, шинж чанарын нэрс). Подвал (хэвлэгч нарын ярианд, сонины хуудасны доод хэсгийг эзэлсэн нийтлэл) зэргийг тус тус нэрлэдэг байна (Розенталь., Теленкова, 2010) зэрэг тодорхойлолтоос харвал мэргэжлийн үг хэллэгийн тодорхой хэсгийг ярианы хэлний үгс эзэлдэг нь харагдаж байна.

Мэргэжлийн үг хэллэг нь ярианы хэллэгээр баялаг тул тухайн хэлний аман аялгуутай нягт холбоотой байдаг. Энэ талаар судалгааны бүтээлд Тухайн мэргэжлийн онцлог шинжийг хадгалсан үгс нь хэрэглээний талбартаа аялгууны онцлогийг байнга хадгалдаг. Олон үг бусад мэргэжлийн хүмүүст ойлгомжгүй байдаг. Жишээлбэл, ажилчдын үгс: “wooden rafting” - модон сал, “кошел” - 5 мянга хүртэлх гуалин; Морь үржүүлэгчид морины явдлын 35 орчим нэрийг хүртэл ялгадаг (“шогших”, “ергөх”, “хатирах”) (Розенталь., Теленкова, 2010) гэжээ. Иймээс ажил мэргэжлийн үг хэллэг нэг талаар нийгмийн аялгууг бүтээж байдаг.

Нийгмийн аялгуу гэдэг нь тодорхой нийгмийн бүлэг, ангийн хэрэглэдэг ярьдаг үг хэллэг, өгүүлбэр, эх хэлний хэрэглээний нэг хэв шинж юм. Нийгмийн аялгуунд нийгэм, улс төр, эдийн засгийн байдал, боловсрол, ажил мэргэжил, түүнчлэн нас, шашин шүтлэг, хүйс, угсаа үндэстэн гэх мэт нийгмийн олон янзын хүчин зүйл нөлөөлдөг. Нийгмийн аялгуу нь газар зүйн бүс нутаг, байгалиас заяагдмал эх хэлний нутгийн аялгуу бус, харин нийгмийн бүлэгтэй холбоотой тусгай үүрэг бүхий харилцаагаар холбогдсон, хэл ярианы бүлэг бөгөөд нийгэм, эдийн засгийн анги, мэргэжил, нас, үндэс угсаа, бүс нутаг зэрэг хүчин зүйлээр тодорхойлогдож болно (Шинэбаяр, 2025:11) гэснийг харьцуулан үзэхэд ажил мэргэжил бол нийгмийн бүлгийг үүсгэдэг үндсэн хэлбэр тул үгийн сангийн онцлогтойн зэрэгцээ нийгмийн аялгууг давхар хадгалдаг ажээ.

Тэгвэл мэргэжлийн үг хэллэгийн ач холбогдлын тухайд мөн хэл шинжлэлийн толь бичигт дурдснаар

Мөрдөгчийн үйл ажиллагаанд хэрэглэгддэг албан ёсны нэр томъёо биш үг хэллэгүүд нь ажилтнууд (хувийн мөрдөгчид) яриандаа зарим зүйлийг илүү товч бөгөөд тодорхой илэрхийлэх зорилгоор ашигладаг. Энэ мэргэжилд олон нийтэд ойлгомжгүй, нөгөө талаар нууцлалтай шуурхай эрэл хайгуулын үйл ажиллагаа, байлдааны тагнуулын үйл ажиллагаа, онцгой байдлын үед хариу арга хэмжээ авах үйл ажиллагаа зэрэг олон үйлдэл байдаг бөгөөд тэдгээрт тохирсон

харилцах үг хэллэг бий хэмээн хилийн албаны болон тагнуулын толь бичигт (Даровских,1999:98 ) тэмдэглэжээ.

Судалгааны бүтээлүүдэд ийнхүү тэмдэглэсэн мэргэжлийн үг нь үгийн сангийн бусад үүсвэр бүрэлдэхүүнтэйгээ тухайлбал, уугуул болон харь үг, нэр томьёотой хэрхэн холбоотой, ямар ялгаатайг илрүүлэхийн зэрэгцээ ямар ямар хэлээс гарал үүсэлтэйг үсчний мэргэжлийн үгийн жишээгээр тогтооно.

### **Судалгааны ажлын зорилго**

Монгол хэлний ажил мэргэжлийн үг хэллэг, түүний үгийн сангийн бүрэлдэхүүнийг тогтоож, утга, бүтцээр ангилах, нэр томьёоны эзлэх хувийг тодорхойлох.

### **Судалгааны ажлын зорилт**

- Үсчний ажил мэргэжлийн үг хэллэгийг мэргэжлийн үсчинтэй уулзаж цуглуулах, ном болон гарын авлагаас хэрэглэгдэхүүн түүвэрлэх
- Цуглуулсан хэрэглэгдэхүүнээ үгийн сангийн бүрэлдэхүүний үүднээс ангилан ялгах
- Ангилсан хэрэглэгдэхүүнээ тооцоолох
- Мэргэжлийн үгийн онцлог хэрэглээг тодруулах

## **1.1. Судалгааны арга зүй**

Энэхүү судалгаа нь үсчний мэргэжлийн үг хэллэгийг орчин цагт судлан үзэж байгаагаараа хам (synchrony) цагийн судалгаанд хамаарах бөгөөд герменевтик аргаар чанарын судалгаа хийсэн нь үсчний мэргэжлийн үг хэллэгийн утгын хувирал өөрчлөлт, шинэчлэлтийг авч үзсэн бол тооны судалгаагаар хэрэглээний давтамжийг тодорхойлж, улмаар харьцуулах, хэл шинжлэлийн задлан шинжлэх болон (analysis) нэгтгэн дүгнэх (synthesis) аргаар бичив.

### **Судалгааны хэрэглэгдэхүүн**

Бид судалгааны хэрэглэгдэхүүн болгож аман болон бичгийн хэлбэрээр цуглуулсан үсчний ажил мэргэжлийн 222 үг хэллэг түүвэрлэсэнээ хэрэглэгдэхүүн болгов. Энэхүү түүвэрт үсчний мэргэжлээр 20-35 жил ажилласан 1 мастер үсчин, 2 мэргэжлийн үсчний ажлын байранд очиж цуглуулсан хэрэглэгдэхүүнээ ашиглав.

## **1.2. Судалгааны практик ач холбогдол**

- Ажил мэргэжлийн үг хэллэгийн гарал, бүтэц, бүрэлдэхүүнийг нарийвчлан тогтоох нь үгийн сангийн судлалд чухал ач холбогдолтой.
- Үгийн сангийн өвөрмөц бүрэлдэхүүний нэг хэсэг болсон ажил мэргэжилтэй хамаатай үг хэллэг нь олон зууны туршид хэрэглэгдсээр ирсэн бөгөөд эдгээр нь нэр томьёоноос ямар ялгаатай болохыг тодруулах нь орчин үеийн нэр томьёоны судлалд чухал байна.

- Эдгээрээс үндэслээд ажил мэргэжлийн үг хэллэгийн хэрэглээний ач холбогдлыг тогтоох

## **2. Мэргэжил, түүний үг хэллэг**

Орчин цагт бий болсон олон ажил мэргэжил, тэдгээрийг бүртгэж ангилан Монгол Улсын үндэсний ажил мэргэжлийн ангиллыг гаргаж, стандарт бий болгосон нь “YAMAT-08” бөгөөд энэ нь 10 үндсэн бүлэгтэй, дотроо 43 дэд бүлэг, 130 бага бүлэг, 432 нэгж бүлгээс бүрдэх шаталсан бүтэцтэй ангилал юм. Үүнээс бид үсчний ажил мэргэжилд холбогдох хэсгийг сурвалжлан үзвэл, нэгж бүлгийн 5141 дугаартай стандартын ажил мэргэжлийн тодорхойлолтод үсчний ажил үүргийг “Үсчин нь үс тайрах, хэлбэр загвар гаргах, будах, шулуун болгох, долгион оруулах, хайчлах зэрэг үйлчилгээг хийнэ (Гэр бүл хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, 2025) гэж тодорхойлоод чиг үүргийг нь:

- а) үс тайрах, угаах, буржийлгах, өнгийг нь хувиргах,
- б) сахал засах, хусах,
- в) үйлчлүүлэгчийн захиалга, хүсэлтээр хиймэл үс тохируулах,
- г) үсний засалт, үс арчилгааны болон үсний бүтээгдэхүүний талаар зөвлөгөө өгөх,
- д) үсний засалтыг хагалдаг газрыг нь өөрчлөх, уртасгах болон хөвсийлгөх зэргээр хэв загварыг өөрчлөх,
- е) үйлчлүүлэгчийн захиалга авах,
- ж) ажлын байраа цэвэрлэх, багаж хэрэгслээ ариутгах, үйлчилгээний төлбөр авах зэрэг багтана хэмээн заажээ.

Манай ард түмэн “Үс сайхан бол зүс сайхан” хэмээн хэлэлцдэг бөгөөд эрт цагаас үсээ ургуулж гол төлөв эрэгтэй, эмэгтэйгүй сүлжиж, боож морь мал унахад тээргүй авч явж иржээ.

Харин дэлхий дахинд үсийг гоёж, засаж эхэлсэн нь олон мянган жилийн түүхтэй бөгөөд Египет, Месопотами, Грек зэрэг эртний соёл иргэншилд энгийн, гоёлын, нийгмийн бүлэгт зориулж үсийг засдаг байсныг олдворууд нотолж байна. Үс засалт нь түүхийн туршид соёл, нийгэм, тэр ч байтугай улс төрийн өөрчлөлтийг тусгаж хувьсан өөрчлөгдөж ирсэн байдаг.

Үс засах нь хүний амьдралын өдөр тутмын хэрэгцээ болж ирсэн үед тусгай мэргэжил үүсэн бий болжээ. Энэ мэргэжлийг дагаад түүний багаж хэрэгсэл, хэв маягийг тэмдэглэсэн үг хэллэг, үйлчлэгч үйлчлүүлэгчийн хоорондоо харилцах үг хэллэг бий болжээ.

### **2.1. Үсчний мэргэжлийн хэлний үг сангийн бүрэлдэхүүн**

Мэргэжлийн үг хэллэг дотроо хэдэн хэдэн төрөл зүйлээс бүрддэг болох нь бидний цуглуулсан хэлний баримтаас тодорхой байна. Судлаачид мэргэжлийн үгийн доторх ярианы хэллэгийг ихэд анхаарсан байдгийг судалгааны удиртгал хэсэгт дурдсан билээ.

Үсчний мэргэжлийн өргөн хэрэглээний үгийг үсчин хүнтэй уулзаж тэмдэглэсэн болон гарын авлага, сүлжээг ашиглан түүвэрлэн үзэхэд, 222 үг болсон бөгөөд хэрэглэгдэхүүнээ үгийн сангийн онцлогоор ялгаж үзвэл, 4 ангилж болохоор байна. Үүнд:

- а. нэр томьёо-85
- б. үсчин хүний хийх үйлдлийг нэрлэсэн үг-74
- в. үсчний мэргэжилд хэрэглэх багаж төхөөрөмжийн нэр-41
- г. үсчинд хэрэглэгдэх бүтээгдэхүүний нэр-22 байна.

а. Аливаа хэлний үгийн сангийн бүрэлдэхүүнд багтах соёл урлаг, шинжлэх ухаан, техник, эдийн засгийн зэрэг тодорхой салбарт тогтмол хэрэглэгдэх, оновчтой ухагдахуун илтгэсэн, ганц утгатай, зориуд зохион боловсруулсан дан болон нийлэмж үгийг нэр томьёо (*term*) (Гэрэлмаа, 2022: 29) гэж үзэхийн сацуу “ нэр томьёо гэдэг бол хийсвэр бэлгэдэл, хоосон тэмдэг биш, өөрийн олон чадамжаараа хэлийг сэлбэж байдаг. “Шинжлэх ухаан, техник, урлаг, соёлын мэргэжлийн ойлголтыг илэрхийлсэн нэр томьёо нь үндэсний утга зохиолын хэлний нэгэн бүрэлдэхүүн мөн” (Пюрбеев, 1984: 6) гэж тодорхойлсон.

Тухайн хэлний нэр томьёо бүрэлдэн тогтох үйл явц хэдэн арван жилд үүсэж тогтдог зүйл биш, уламжлал, соёл, ахуйг тусгасан олон зуун жилийн турш үгийн санд бүрэлдэн тогтсон хэсэг байдаг тул үсчний мэргэжилд хамаарах нэр томьёо нийгэм болоод цаг хугацааны хувирал өөрчлөлтийг тусгаж ирсэн шинжтэй байна.

Үсчний мэргэжилд хэрэглэж буй нэр томьёо 85 байгаа нь тухайн мэргэжлийн үгийн сангийн 38%-ийг эзэлж байна. Үсчний ажил мэргэжилд хэрэглэх нэр томьёог 2 үндсэн бүлэгт хувааж болно.

Нэгдүгээрт, үс засах хэлбэр маягийг нэрлэсэн *боб тайралт*, *далайн мөгөөрс тайралт*, *микси тайралт*, *наймаалж тайралт*, *мохоо зүсэлт*, *тасархай тайралт* зэргийг нэр томьёоны шинжтэй байгаагийн шалтгаан нь нэг нь нөгөөгөөсөө ялгарч үс засалтын ухагдахуун бий болгосны зэрэгцээ зарим нь “мохоо зүсэлт”, “тасархай тайралт” гэж шууд нэрлэлт үүсгэж байгаа зарим нь зүйрлэх аргаар үүссэн нэр томьёо ч байна. Тухайлбал, “*далайн мөгөөрс тайралт*” гэснээр тухайн амьтантай адил хэлбэрийг үүсгэж нэршүүлсэн байна. Үүнтэй адилаар олон хөлтэй мэт урт үсийг тайрах аргыг “*наймаалж тайралт*” гэсэн байх жишээтэй.

Хоёрдугаарт, тайралт, хуйхны эмчилгээ, үсний оношилгоо гээд тухайн салбарт түгээмэл хэрэглэх ухагдахуун илэрхийлж буй бүлэг үгс бол нэр томьёо юм. Энэ бүлэгт монголчуудын уламжлалт *гээг, сэвлэг, даахь, тав гээг, гурваар дарсан гээг* зэрэг монгол хэлнийхээ үгийн сангаас нэр томьёоны үүргээр хэрэглэж буй үгс ч багтана.

Үсчний мэргэжлийн нэр томьёог орлодог ярианы хэлний үгс байх нь элбэг байна. Тухайлбал омбри будалтыг *уусгаж будах, омбри хийх, үзүүр рүү уусгах* гэх буюу үсийг цайруулахыг *супрадах, сор тавихыг сорлох, уурган эмчилгээг уураг*

өгөх, шилэн хүзүүнээс давсан үсийг авахыг *шуух*, мөн гоёлын засалтад урт үсийг дээш нь боохыг *шуух* гэх зэргээр мэргэжлийн ярианы хэлэнд хэрэглэнэ.

б. Үсчний мэргэжил бол үйлчилгээний ажил бөгөөд хүнд үйлчлэх олон үйлдлийг нэрлэсэн үйл үгс 74 байгаа нь 33%-ийг эзэлж байна. Үгийн аймгаар ангилбал бүгд үйл үг бөгөөд эдгээрийг дотор нь үс засахтай холбоотой (*тайрах, засах, нимгэлэх, захлах, шингэлэх, хусах, шатлах, богиносгох, өөлөх, сэнсдэх, угаах*) зэрэг үг хэллэг, үсийг гоёхтой холбоотой (*сорлох, будах, хими хийх, супрадах, ороох, сүлжих, лакдах, тогтоох, гельдэх*) зэрэг үг, үсийг эрүүлжүүлэхтэй холбоотой (*үс оношлох, эмчлэх, уураг түрхэх, хуйх цэвэрлэх*) зэрэг олон үйл үг байгаа нь тухайн мэргэжлийн хүний олон үйл ажиллагааг давхар харуулж байгаа хэрэг юм.

в. Үсчний мэргэжилд хэрэглэх багаж төхөөрөмжийн нэрс *хайч, сам* зэргээс эхлээд өдгөө цагт *сэнс, шуршүүр, алчуур, нөмрөг* гэх зэргээр үргэлжлэх бөгөөд орчин үед тухайн мэргэжлийн чадвар, боломж хөгжихийн хэрээр төрөл зүйл нь ихсэж, нарийсаж байна. Ийм багаж төхөөрөмжийн нэр 41 байгаа нь 18,5%-ийг эзэлж байна. Тухайлбал, *хайч* гэхэд *гүдгэр ирмэгтэй, налуу ирмэгтэй, шингэлэх, офсет бариултай, краны бариултай* гэх мэтээр төрөл бүрийн тайралтад зориулагдсан байдаг ажээ.

Үсчний мэргэжил орчин үежиж *хими хийх аппарат, уурын аппарат, үсний индүү, хайч, сэнс* цөм цахилгаан хэрэгсэл болж ажлын бүтээмж хурд нэмэгдсэн байна.

г. Үсчний хэрэглэх бүтээгдэхүүний нэр харьцангуй олон төрөлтэй болж жилээс жилд нэмэгдэх хандлагатай байна. Үсийг угаах, арчлах, хэлбэржүүлэхэд шаардлагатай бүтээгдэхүүн брэнд улам олширч зориулалт нь ихэссээр байна. Үс угаадаг шампунийг гэхэд үйлчлэлээр нь *хуурай үсний, тослогтой үсний, хагтай үсний, будагтай үсний* гэх мэтээр, хэнд зориулснаар *хүүхдийн шампунь, эрэгтэй үсний шампунь, эмэгтэй шампунь, буурал үсний шампунь, гэр бүлийн шампунь, нэг удаагийн шампунь* гэх буюу брэндээр нь *Пантен шампунь, СиСи шампунь, Эластин шампунь, Вүү Вүү шампунь* гэх мэтээр тоо томшгүй ангилж болох ч шампунь болгоны оноосон нэрийг бүртгэн оруулах боломжгүй юм. Бидний хэрэглэгдэхүүн дотор 22 үг байгаа нь нийт үгийн 10 %-ийг эзэлж байна.

Сүүлийн жилүүдэд үс арчилгааны бүтээгдэхүүн өргөн хэрэглээтэй болж тэдгээрийг нэрлэсэн *үсний маск, үсний эссэнс, үсний тос, серум, уураг* зэрэг нь ерөнхий нэр бөгөөд тус бүрдээ оноосон нэртэй байна. Учир нь оноосон нэр бол нэг төрлийн олон юмыг өөр хооронд нь ялгах хэрэгцээнээс үүсдэг тул *Шварцкофын үсний тос, Давина серум, Карла уураг* гэсэн нэрлэлт бий болжээ.



Диаграмм №1. Үсчний мэргэжлийн үгийн бүрэлдэхүүний харьцаа

Энэхүү диаграммаас харвал, нэр томьёо болоод үйлдэл заасан үгс харьцангуй ойр хэмжээтэй байгаа бөгөөд өдөр тутамд эдгээрийг солин хэрэглэдэг байна.

## 2.2. Үсчний мэргэжлийн үг хэллэгийн гарал

Энэхүү судалгаандаа үсчний ажил мэргэжилд өргөн хэрэглэдэг 222 үгийг түүвэрлэснээ үгийн сангийн гарлын үүднээс авч үзвэл, уугуул үг, ормол үг гэсэн 2 хэсгээс бүрдэж байна.

### а. Үсчний мэргэжлийн уугуул үг

Үгийн сангийн уугуул үг гэдэг бол олон зуун жилийн туршид хэлний үгийн сан үүсэн бүрэлдэхэд л юм, ухагдахуун, хэлний тэмдэг гэх гурамсан харьцаа, шүтэлцээ нь тухайн ард түмний сэтгэхүй, сэтгэлгээгээр үүдэж үүссэн үг (МХС, 2020, Х: 27)-ийг хэлдэг ажээ.

Уугуул үг бол эх хэлний хэрэглээний явцад давтамж их байж, бусад үглэвэртэй зохицох дархлаатай тул энэ шинжээр нь харь үгээс ялгаж болно (МХС, 2020, Х:54). Үйл үгийг энэ шинжээр нь авч үзэхийн зэрэгцээ хэрхэн олон үглэвэр үүсгэх буюу үгийн сангийн нэгж үүсгэдэг шинжээр нь ч тодорхойлж болно.

Бидний цуглуулсан хэрэглэгдэхүүний 149 буюу 67.2 % нь *үс, хайч, хөмрөг* гэх дан үг *үс тайрах, шулуун болгох, үс арчилгаа* зэрэг ямар нэг гадаад үг оролцоогүй бүтсэн үгс байна.

Уугуул үгээс шинэ үг үүсэх үгийн сангийн болон хэл зүйн аргууд байна. Үгийн сангийн аргын тухайд үгийн утга шилжих болон утга салбарлаж шинэ үг үүсгэдэг.

Иймээс үсчний ажил мэргэжлийн уугуул үгийн дотроос *үс засах* гэдгийн “засах” хэмээх үйл үгийг авч үзье. Толь бичигт тэмдэглэгдсэн утгаараа

### ***I үйл.***

1. Эвдэрч гэмтсэн зүйлийг сэлбэж янзлан хэвийн байдалд нь эргэж оруулах
2. Бичсэн, зохиосон зүйлийн алдаа мэдгийг шүүн тунгаах, нягтлан ариутгах;



3. Юмыг бүтээн байгуулах, шинээр бий болгох
4. Аятай таатай болгох, төвхнүүлэх

### II үйл.

1. Эр мал, амьтныг агтлах; хөнгөлөх
2. хуучир. Эрэгтэй хүнийг тайган болгох.

### III үйл.

1. Эмчилгээ, сувилгаа хийх

### IV үйл.

1. Юмны байдал дээшлэх  
**машин засах**-машины эвдрэл гэмтлийг янзалж, хэвийн ажиллагаатай болгох
2. **тэрэг засах**-тэрэг засварлах
3. **засан хүмүүжүүлэх**-ялт буруу үйл, гэмт хэрэг хийсэн этгээдийг нийгмээс тусгаарлахгүйгээр, шүүхийн шийдвэрт заасан тодорхой хугацааны дотор албадан хөдөлмөрлүүлэх
4. **явдлаа засах**-гажуу буруу үйл ажлыг засах
5. **зам засах** – а. зам гүүр шинээр барих;  
б. замын эвдрэл гэмтлийг сэлбэн сайжруулах
6. **гэр засах**- а. гэрийн бүрээс, модыг сэлбэх, шинэтгэх;  
б. гэрийн хэв хэлбэрийг засч барих
7. **байшин засах**- а. байшингийн гадна дотно талыг сэлбэж шинэчлэх;  
б. байшингийн доторхыг тохижуулах төвхнүүлэх
8. **биеэ засах** - а. биеийн өвчин эмгэгийг сувилж эмчлүүлэх;  
б. биеэ цэвэр үзэмжтэй зөв авч явах
9. **бөх засах** - барилдах бөхийг дагаж харгалзан барилдуулах
10. **буурь засах** - буурьтай болгох, буух газраа тэгшлэн янзлах
11. **бууц засах** - а. гэр барих газрыг тохируулан янзлах;  
б. малын хот, хэвтрийг цэвэрлэх
12. **гэр засах**-а.гэрийн модыг сэлбэх, шинэтгэх; б.гэрийн хэв хэлбэрийг сайхан болгон барих **өнгө засах**-а.хүний нүүр царай өнгөжин жавхаажих;
13. б.мал тарга тэвээрэг орох гэх мэт 30 гаруй утгатай байж олон шинэ утгын үндэс болсны нэг нь үс засах бөгөөд **үс засах**-а.гээг үс сүлжин янзлах;  
б.гээг үсийг уран гоё хэв загвартай болгох;  
в.үс тайрч богиносгох гэсэн утгыг тэмдэглэжээ.

Үстэй холбоотой “засах” үйл үгийн утга нь мөн морины ургасан дэлийг хайчилж сайхан хэлбэрт оруулахтай жишиж үүссэн утга гэж үзэж болох юм.

Уугуул үгийн сан дотор энэ мэтээр *арьс хөрс хусах* гэдэгтэй адилтгаж үүссэн *үс хусах, үс авах* гэдэг хэллэг, *дэл сүүл хяргах*-тай адилтгаж үүссэн *үс хяргах, үс богиносгох, үс тайрах, үс өөлөх* зэрэг нийлэмж үг уугуул үгийн сангаас утга салбарлан үүсжээ.

Үсчний мэргэжилд орчин цагт хэрэглэж буй *будах, шингэлэх, хатаах, сэнсдэх, өнгө гаргах, үс арчилгаа, үсний тэжээл, үс буржийлгах, шулуутгах* гэх мэт өдий төдий уугуул үг байна.

Дээрх толь бичигт тэмдэглэсэн “биеэ засах, явдлаа засах” хэмээх хоёр үг нь “засах” үйл үгийн гадаад хэлбэрийг янзалж аятай болгох гэдгээс хүний үйлдэл, явдал, өөрийн биеэ зөв болгох гэсэн утгатай шилжмэл утгаар үүссэн үг юм.

Иймээс ажил мэргэжлийн үгийн сангийн суурь бол уугуул үг гэдэг нь маргаангүй.

б. Үсчний мэргэжлийн ормол үг

Үсний засалт бол цаг үеийн хэв маягийг нарийн тусгадаг онцлогтой мэргэжил тул цаг үе болгонд өөрчлөгдөн хувирч байдаг онцлогтой. Энэхүү хувирал өөрчлөлт болгоныг тусгасан үг хэллэг үсчний мэргэжил төдийгүй нийгэмд үлдэж хоцордог байна.

Үсчний мэргэжлийн үгийн сангийн бүрэлдэхүүний тодорхой хэсгийг бүтээгдэхүүний нэр болон үсний загвар маягийг нэрлэсэн ормол үг эзэлж байна. Энэ нь бидний цуглуулсан хэрэглэгдэхүүний 73 нь буюу 32.9% -ийг эзэлж байгаа нь бага биш хувь юм.

Үс засах арга маяг цаг ямагт өөрчлөгдөн хувирч байдаг тул тухайн цаг үеийн тусгал гэж хэлж болно.

1960-аад он бол загварын ертөнцөд онцгой дүр төрхийг бий болгосон үе бөгөөд энэ үед урлаг уран сайхан цэцэглэн хөгжиж дэлхий дахинд хурдан хэмнэлт хөгжим рок-н-ролл хүчээ авч үүнийг дагаад үсний хэлбэр маяг ч хувирснаар твигги, пикси, геометр каре хөгжжээ. Иймээс 60-аад оны залуус өргөн өмд өмсөж эрэгтэй нь үсээ ургуулан бүсгүйчүүд нь үсэн дотроо лааз хийж өндөрлөж засдаг байсан нь үсчний мэргэжлийн хэллэгээр бол “твигги” засалт ажээ. Харин үүнээс хойш үсийг богиносгон хөвсийлгөж засах болсон нь пикси засалт бөгөөд энэ нь англи хэлнээ *pixie haircut* гэж нэрлэгдэн одоо ч ажил хэрэгч бүсгүйчүүдийн түгээмэл дүр төрх хэвээр байгаа богино бөгөөд загварлаг үсний нэр билээ.

Харин үсчний хэрэглэдэг багаж хэрэгсэл, бүтээгдэхүүний нэр маш олон бөгөөд өдгөө хэрэглэгдэхээ больсон заримыг нь бид олж тогтоож ч чадахгүй биз ээ.

Нөгөөтэйгүүр, бидний өдгөө хэрэглэж байгаа зарим ормол үгийн орж ирсэн он цаг хугацаа ч өөр өөр байна. Тухайлбал, *претек, шампунь, лак, хими, чёлк, спорт, норматив, шилка* зэрэг үгс нь орос хэлээр дамжин монгол хэлнээ орж үсчний салбарт хэрэглэгдсэн үгс болно.

Эдгээрээс хими хэмээх үгийн гарлыг хөөж үзвэл, эртний Грекийн *khemeia* (χημεία) гэсэн үгээс гаралтай бөгөөд метал цутгах, металлурги болон “Би цутгана” гэсэн утгатай *kheo* (χέω) гэдэг үйл үгээс гаралтай. Энэхүү грек хэллэгийг араб хэлэнд аль-химия (أىمىكلا) нэрээр зээлсэн бөгөөд хожим нь англи хэлээр “алхими” гэсэн нэр томьёо болон хувирчээ. Сэргэн мандалтын үед

“ал-” (араб хэлний) утгварыг “алхими”-аас хасаж, шинээр гарч ирж буй шинжлэх ухааны салбарыг тодорхойлохын тулд нэр томъёог “химич” болон “хими” болгон өөрчилсөн (Etymonline, 2020) Улмаар энэ үгийг дэлхий нийтээр дараах үндсэн 2 утгаар хэрэглэдэг байна. Үүнд:

1. биетийг бүрдүүлдэг бодис, тэдгээрийн шинж чанар, урвалыг судлах, эдгээр урвалыг ашиглан шинэ бодис үүсгэх шинжлэх ухааны салбар. *биеийн химийн найрлага, шинж чанар*. “Өвчтний цусны химийн шинжилгээг тогтмол хийдэг”

2. хүмүүсийн хоорондын сэтгэл хөдлөлийн болон сэтгэл зүйн нарийн төвөгтэй харилцан үйлчлэл. “Тэдний үерхэл сэтгэлийн хүчтэй харилцан нөлөөллөөс үүдэлтэй” гэж Оксфордын толь бичигт тодорхойлжээ.

Үсчний мэргэжлийн чухал нэг хэсэг нь болсон “хими” хэмээх үг нь химийн бодисоор үсийг буржийлгаж тэр хэвийг нь хадгалах, хэрэглэх бодисын нэр болон үлджээ. Энэ үг нь үгийн сангийн үндсэн утгаас утга шилжүүлэн үүссэн үг болно. Химийн төрөл зүйл олшрох тусам түүнийг нэрлэсэн нэр олширдог хуулиар *усан хими, тосон хими, буржгар хими, шулуун хими, химийн аппарат, химийн нэгдүгээр хор, химийн хоёрдугаар хор* гэх мэтээр олон нэрлэлт үүсгэсэн байна.

Өнөө цагт хэрэглэж байгаа харь үг нь гол төлөв англи хэлээс гаралтай үгс байгаагаараа онцлог. *Маникюр, массаж, эссэнз, гель, кератин, серум* гэх зэргээр нэр үгээр байхаас гадна тухайн бүтээгдэхүүнийг хэрэглэсэн үед лакдах, гельдэх цаашлаад массажлах, маникюрдэх зэрэг ярианы хэлэнд үйл үг үүсгээд байгаа нь эх хэлний хэм хэмжээнд тохиромжтой биш үзэгдэл юм.

Гадаад хэлний үгтэй хэллэгээр үсчний ажил мэргэжлийн үг хэллэг харьцангуй их байгаа нь нийт үгийн 73 нь буюу 32.9% нь гадаад үг оролцсон нийлэмж үгээр илэрч байна. Тухайлбал,

<i>офсет бариултай хайч</i>	<i>сөрөг ион ялгаруулдаг үсний индүү</i>
<i>үсний лазер эмчилгээ</i>	<i>авангард засалт</i>
<i>2D оношилгооны аппарат</i>	<i>хүчилтөрөгчийн аппаратад суулгах</i>
<i>спорт засалт</i>	<i>хэлбэржүүлэгч вакс гэх мэт.</i>

Үсчний ажил мэргэжлийн салбарт тоног төхөөрөмж, бүтээгдэхүүнийг даган орж ирсэн гадаад хэлний ормол үг цөөнгүй байгаа нь бидний судалгаанаас харагдаж байна. Бүтээгдэхүүний оноосон нэрийг орчуулах боломжгүй бол зарим бодис, тоног төхөөрөмжийн нэрийг орчуулахыг эрмэлзэх нь зүйтэй юм. Тухайлбал, *кератин* гэдгийг *уураг*, *маск* гэдгийг *бигнүүр* гэх зэргээр орчуулан хэрэглэж болмоор.

### 2.3 Үсчний мэргэжлийн үгийн бүтэц

Үсчний мэргэжлийн үгийг бүтцээр авч үзвэл, дан болон нийлмэл бүтэцтэй байна.

а. Дан үг нь язгуураараа байгаа үйл үг “засах”, “сүлжих”, “тайрах” зэргээс гадна “үс”, “хайч”, “сам” зэрэг нэр үгээс бүтсэн үгс байна.

б.Дан үг боловч дагавар залгаж бүтсэн үсчний ажил мэргэжлийн үгэнд түгээмэл хэрэглэгдэх -л, -лт, -гч, -уул<sup>2</sup>, -лга зэрэг цөөвтөр дагавар давтамж өндөртэй байгаа бөгөөд үүсмэл 32 үг тохиолдож байгаа нь 14,4 %-ийг эзэлнэ.

-л дагавар бүтээлч шинжтэй байна. Энэхүү дагавар нь жинхэнэ нэр, тооны нэр, тэмдэг нэрд залгаж үйл үг бүтээхдээ тухайн юмны шинжийн дагуу үйл үг үүсгэдэг. Тухайбал, нимгэлэх гэдэг нь үсний өтгөрсөн хэсгийг хасаж багасгах гэсэн утгатай болно. Энэ мэтээр

нимгэн+л +х,	өө+л+х,
зах+л+х,	үзүүр+л+х
сор+л+х	жигжиг+л+х зэрэг үүсмэл үг бүтээнэ.

-лт дагавраар хэлбэржсэн үгс. Энэ дагаврын утгыг Л.Болд “... үйлийн явцыг харуулсан, үйлийн үр дүнг харуулсан, үйлийн нэрийг заасан, тухайн үйлд хэрэглэгдэх юмын нэрийг заана” (Болд, 1986:58) хэмээн хэд хэдэн бүлэгт хувааж үзсэн билээ.

Үсчний ажил мэргэжлийн үгэнд үйлийн үр дүнг илтгэсэн	
тайр+лт	буд+лт
сор+л+лт	уус+га+лт
зас+лт	ороо+лт
шуу+лт	хус+лт зэрэг үгс тохиолдоно.

-уул<sup>2</sup> дагавар

Нэрийн үгийн дараа -ж, -жир дагавар залгаж араас нь -уул<sup>2</sup> дагавар залгасан жишээг харвал

анги+жир+уул гэсэн язгуураас ангижируулагч,  
гялалз+уул гэсэн язгуураас гялалзуулагч

бэх+ж+үүл гэсэн язгуураас -гч дагавар залгаж бэхжүүлэгч зэрэг нэр үг бүтээх үндэс болно.

-лга-дагаврыг дүрслэх үйл язгуурт залган шинэ үг бүтээж байна.

бурж+ ий+лга

хөвс+ий+лгө гэх мэт.

-д дагавраар - сэнс+д гэснээс өөр үг тэмдэглэгдээгүй байна.

Үгийн бүтцийн үүднээс хоёр буюу түүнээс дээш үг нэгдэж, үг нийлэх аргаар үг бүтээж үсчний ажил мэргэжилд хэрэглэж байгаа монгол хэлнээ үг бүтээх нийтлэг аргын нэг болно.

Үсчний ажил мэргэжлийн үгийн санд үйлдэл заасан үг олон байгааг дээр үгийн сангийн бүрэлдэхүүн дотор бичсэн билээ. Ийм ч учраас нийлэмж үг бүтээж байгаа гол үг нь үйл үг байх нь энэ салбарын онцлог байна.

“**тайрах**” үйл үгэнд захируулан үүссэн:

*дугуйлж тайрах*

*тэгшилж тайрах*

*чёлк тайрах*

*шаталж тайрах*

*хэлбэртэй тайрах*

*налуу тайрах гэх мэт.*

“хийх” үйл үгэнд захируулан үүссэн:

<i>оношилгоо хийх</i>	<i>гүн цэвэрлэгээ хийх</i>
<i>залгаа хийх</i>	<i>хими хийх</i>
<i>хуйханд эмчилгээ хийх</i>	<i>гоёлын засалт хийх</i>
<i>хиймэл үс хийх</i>	<i>маникюр хийх гэх мэт.</i>

Үсчний мэргэжлийн нийлэмж үгийн өөр нэг хэлбэр нь ормол үгтэй уугуул үг нийлж шинэ үг бүтээх явдал юм.

Жишээлбэл, гель түрхэх, вакс түрхэх, авангард засалт, хиппи засалт гэх мэт үгс нь гель, вакс гэх зэрэг бүтээгдэхүүний нэрийг үйл үгэнд заахын тийн ялгалаар захируулж үүссэн үгс юм. Харин авангард, хиппи зэрэг нэр үгийг мөн нэр үгэнд үндсээр хамжуулан нийлэмж үг бүтээж байна.

Үсчний мэргэжлийн үг хэллэгийн гүгийн бүтцийн үүднээс тооцоолоход үсчний мэргэжлийн дан үг 51 буюу 23% байгаа бол нийлмэл бүтэцтэй үг хэллэг 171 буюу 77% -ийг эзэлж байна.

### Дүгнэлт

1. Үсчний ажил мэргэжлийн үг хэллэгийг судлан үзэхэд үсчний мэргэжил цаг үеийн өнгө төрх, хэв маягийг дуурайн хөгждөг онцлогтой агаад энэ өсөлт хөгжилт нь үгийн санд тусаж шинэ үг хэллэг олноор бий болохын сацуу хэрэглээнээс гарсан үг нь хуучирдаг байна.
2. Тухайн мэргэжилд хэрэглэгдэх нэр томъёо болоод үйлдэл илэрхийлэх үг нь хэмжээний хувьд ойролцоо боловч нэр томъёог жирийн хэрэглээнд ярианы үгээр солин хэрэглэх нь түгээмэл байдаг ажээ.
3. Орчин үеийн чиг хандлагыг дагаад тус ажил мэргэжлийн хүрээнд гадаадын тоног төхөөрөмж, бүтээгдэхүүний нэр олноор орж ирж тэдгээрийг орчуулалгүй хэрэглэх нь түгээмэл байгааг цаашид анхаарч боломжтой үгийг орчуулах нь чухал байна.

### Ном зүй

- Болд, Л.** (1988). *Орчин цагийн монгол хэлний дагавар*. Улаанбаатар. [Bold, L. *Orchin tsagyn mongol khelnii dagavar*. [The suffix of Modern Mongolian language] Ulaanbaatar. 1986.]
- Гэр Бүл, Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын яам.** “Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт-08.” <https://yamat.mlsp.gov.mn/>. 9 4, 2025. <https://yamat.mlsp.gov.mn/public/> (accessed 9 4, 2025).
- Гэрэлмаа, Г.** (2020). *Монгол хэлний нэр томъёо бүтэх задлаг ба нийлэг хэв шинж*. Улаанбаатар: МУИС Пресс хэвлэлийн газар. [Gerelmaa, G. *Mongol khelnii ner tomiyo bütekh zadlag bolon niileg khev shinj*. [Analytic and synthetic methods of creating terms in Mongolian] Ulaanbaatar: NUM Press. 2020.]

- Даровских Ю.В., Матвеев Т.Г., Ганиев Т.Г.** (1999). Основы оперативно-розыскной деятельности: тематический словарь понятий и определений.- Тюмень [Fundamentals of operational-search activities: a thematic dictionary of concepts and definitions. Tyumen. 1999.]
- Монгол хэл судлал.** (МХС), (2022). *Үгийн сан судлал. X боть.* Улаанбаатар: МУИС Пресс хэвлэлийн газар [Mongol khel sudlal. *Ügiin san sudlal* [Study of Mongolian language. Lexicology] Volume X. Ulaanbaatar: NUM Press. 2020.]
- Новый словарь иностранных слов (НСИС).** (2006). С.523, Москва, II изд. [New dictionary of foreign words. Moscow. 2006.]
- Пюрбеев, Г.Ц.** (1984). *Современная монгольская терминология.* Москва: Наука [Pyurbeev.G.Ts. *Modern Mongolian Terminology.* Moscow: Science. 1984]
- Etymonline.** <https://www.etymonline.com/>. 2020. <https://www.etymonline.com/word/chemistry>.
- Розенталь Д. Э., Теленкова М. А.** (1976) “Словарь лингвистических терминов.” [www.slovaronline.com](http://www.slovaronline.com) . 10 3, 2010. <https://rus-lingvistic-term.slovaronline.com/> (accessed 10 3, 2010).
- Төмөрцэрэн, Ж.** (1974). *Монгол хэлний үгийн сангийн судлал.* Улаанбаатар: УХГ [Tumurtseren, J. *Mongol khelnii ügiin sangiin sudlal* [Mongolian Lexicology] Ulaanbaatar: State Publishing. 1974.]
- Шинэбаяр, О.** (2025). *Нийгмийн аялгуу судлал.* Улаанбаатар: Битпресс ХХК. [Shinebayar, O. *Niigmiin ayalguu sudlal* [Social dialect]. Ulaanbaatar: Bitpress LLC. 2025.]
- Etymonline.** <https://www.etymonline.com/>. 2020. <https://www.etymonline.com/word/chemistry>.